

БНХАУ-ЫН СОФТ ХҮЧ ЧАДЛЫН ӨСӨЛТ, ТҮҮНИЙ ОЛОН УЛСЫН ҮР НӨЛӨӨ

*Д.Шүрхүү**

Өрнөдийн хэвлэлийн хуудаснаа Хятадын үсрэнгүй хөгжил, түүнийг дагасан нөлөө, хүч чадлын өсөлтийн тухай, мөн “хятадын аюул”-ын тухай олонтаа бичиж байна. Цаашдаа энэ орон дэлхийн супер их гүрэн болбол ямар бодлого явуулах бол, дэлхийн бодлогод хэр зэрэг үүрэг гүйцэтгэх бол, ямар аюул занал авчрах бол гэдэг айдас дэлхий дахинаа ялангуяа Хятадын ойр орчмын бүс нутгийн орнуудад хүчтэй хэвээр байна. Жилд 2.6 триллион ам.долларын дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ үйлдвэрлэдэг, 2 триллион долларын гадаад худалдаа хийдэг, 2.3 сая хүнтэй армия жил бүр 350 тэрбум юань буюу \$45 тэрбумаар¹ зузаатгаж /ДНБ-ний 5-6% тэнцэх төсөв/, тэнгис, агаар, сансарт хүч чадлаа харуулах болсон хөршөөсөө эмээх үндэслэл хангалттай. Хятад үндэстний түүх бусад их үндэстнүүдийн нэгэн адил хил залгаа жижиг үндэстнүүдээ уусган, нутаг дэвсгэрээ тэлсээр ирсэн түүх гэдгийг хөрш орнууд сайн мэднэ. Эртнээс инагш өрсөлдөгч, өстөн, хараа хяналтанд нь орж гарч байсан эдүгээ хүчирхэгжин чангарч буй их хань үндэстнээс цэрвэн сэрэмжлэх үү, эсвэл ойртон нөхөрлөж, хамтран ажиллах уу гэдэг асуудал БНХАУ-тай далай болон хуурай газраар хиллэдэг 30 орчим орнуудад одоо ч хамгийн маргаантай, улс төрийн эмзэг асуудлын нэг болоод байна.

Гэхдээ хол ойрын олон орнууд Хятад орныг аюул занал гэхээс илүүтэй том зах зээл, хөгжлийн боломж, цаг алдалгүй тэр боломжийг ашиглах нь чухал хэмээн үзэх хандлага сүүлийн үед давамгайлах боллоо. Бодлогын чиг хандлагын хувьсал өөрчлөлтөд хоёр чухал хүчин зүйл нөлөөлсөн хэмээн үзэж болох юм. Нэгд, цаг хугацаа, хоёрт Хятадын софт буюу зөөлөн хүч чадлын өсөлтийн шууд үр дүн юм.

Глобалчлалын түрэлт, шинжлэх ухаан технологийн үсрэнгүй хөгжлийн үр дүнд аливаа юмс үзэгдлийн хувьсал өөрчлөлт асар хурдтай явагдаж байна. Хятадын зах зээлд гарах, хөрөнгө оруулалт шингээх чадавхи, потенциалыг өнөө маргаашиггүй ашиглахгүй бол эсвэл хөгжлөөрөө хол хоцрох, эсвэл байр сууриа бусдад алдах цаг хугацааны хүчтэй шахалтанд цөөнгүй улс орон орчихоод байна. Өөрөөр хэлбэл, Хятад улсын үсрэнгүй хөгжил хэр удаан үргэлжлэхийг хэн ч таамаглаж чадахгүй байгаа явдал цаг хугацааны гол хүчин зүйл юм. Зарим судлаачид энэ эрчээрээ хөгжбөл тун удахгүй АНУ-ыг гүйцэж түрүүлэн дэлхийн эдийн засгийн супер гүрэн болно гэж таамаглаж байхад, нөгөө хэсэг судлаачид Хятад улс экологи, нийгэм, улс төрийн гүн гүнзгий хямралд өртөж, зохистой харьцаа алдагдсаны улмаас дэлхийг хөлдөө

* Д.Шүрхүү - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

чирэн нуран унах тухай мэдэгдэж байна. Иймд Хятадын үсрэнгүй хөгжлийг даган гарч ирсэн том зах зээлийг ашиглаж чадахгүй өнгөрөх, хөгжил урт хугацаанд үргэлжилбээс боломжийг ашиглахад цаг алдах, санаачлагаа бусдад алдах аюул Хятадтай харилцаж буй бүх орнуудад адилхан тулгарч байна. Хоёр дахь хүчин зүйл буюу Хятадын эрх баригчид сүүлийн жилүүдэд зөөлөн хүч чадлын үүрэг ач холбогдлыг нэн чухалчлан, маш идэвхитэй бодлого явуулж байгаа явдал юм.

Софт хүч чадлын үүрэг ач холбогдол

Юуны өмнө софт хүч чадал гэж юу вэ? Үүнд ямар асуудлууд хамаарч байна вэ? Софт хүч чадлын онолын үндэслэлийг гаргаж ирсэн америкийн эрдэмтэн Иосеф Най хүйтэн дайн дуусч хоёр хэт их гүрний дэлхий дахиныг хамарсан цэргийн сөргөлдөөн арилснаар олон улсын харилцаанд эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёлын зэрэг хүчин зүйлсийн үүрэг улам нэмэгдэж байна. Аливаа улс түүний дотор АНУ хүч чадлын шинэ эх сурвалж, софт хүч чадлыг ашиглаж сурах хэрэгтэй үзсэн Най софт хүч чадалд наад зах нь 3 зүйлийг хамааруулах ёстой гэж үзсэн байна. Үүнд: 1-рт, Эрх чөлөө, ардчилал, хүний эрх зэрэг оюун санааны үнэт зүйлс, 2-рт чөлөөт зах зээлийн эдийн засаг, 3-рт соёл иргэншил зэргийг оруулсан байна. Тэрбээр софт хүч чадал хатуу хүч чадлын үргэлжлэл бөгөөд өөр хоорондоо нягт уялдаатай хэмээн тодорхойлжээ.² Түүний дэвшүүлж буй бас нэг чухал санаа бол хүч чадал хөрөнгийн төвлөрлөөс мэдээллийн төвлөрөл рүү шилжиж буй явдал юм. Мэдээллийн хүч чадал улс төр, эдийн засаг, соёл, нийгэм гэх мэт нийгмийн бүхий салбарыг хамарч, 21-р зуунд мэдээллийн техник хүч чадлын хамгийн чухал эх сурвалж болсоныг онцлон тэмдэглэсэн юм.³ Софт хүч чадал, ялангуяа мэдээллийн хүч чадал бол тулган хүлээлгэх бус татан дагуулах шинжтэйгээрээ ялгардаг байна.⁴

Хятадын эрдэмтэд ч өөрсдийн софт хүч чадлыг ихэд чухалчлан үзэж, олон талаас нь судалж байна. Тухайлбал, Шанхайн Фуданий их сургуулийн профессор Ван Хунин соёл бол төрийн бодлогын суурь дэвсгэр төдийгүй бусад орны байдалд ч нөлөөлж чадахуйц нэгэн зүйл хүч чадал, чадавхи юм. Мөн түүнчлэн “улс төрийн систем, удирдлага”, “үндэстний ёс суртахуун, ухамсар”, “нийгмийн олон улсын дүр төрх”, “төрийн гадаад бодлогын стратеги”, “олон улсын дэг журмыг тодорхойлох, нөлөөлөх чадавхи”, “шинжлэх ухаан-техникийн хөгжил” гэсэн 6 зүйлийг улс орны хүч чадлын үндэс суурь хэмээн тодорхойлжээ.⁵

Хэдийгээр 2007 онд хятад барааны нэр хүнд унаж, хүүхдийн тоглоом, эм, хүнсний барааны чанар, аюулгүй байдлын талаарх “том шуугиан” дэлхий даяар өрнөж, Хятадын байгаль орчны бохирдол үндэстний хүрээ хязгаараас хальж, цэрэг, санхүүгийн хүч чадал нь өдөр хоногоор зузаарч /валютын нөөц-\$1 430.0 тэрбум⁶/, “Хятадын аюул”

өсөн нэмэгдсээр байгаа боловч БНХАУ-ыг талархан үздэг, найрсаг харилцаат орны тоо, худалдаа хөрөнгө оруулалт хийх сонирхолтой том компаниудын тоо нэмэгдсээр байна. Хөгжиж буй орнуудын дунд Бээжинг худалдааны том түнш орон, хөрөнгө оруулагч, хандивлагч, үлгэр дууриал, итгэл найдвар хэмээн үзэх нь нэмэгдэж байна.

Үүний нөгөө талд Жуннанхайн эрх баригчид Хятад улс бол энхийг эрхэмлэсэн, хөгжил дэвшилд тэмүүлсэн, хүн төрөлхтөний соёл иргэншлийн том өлгий, хөгжиж буй орнуудын өмөг түшиг, олон улсын аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадахуйц, дэлхийн хүчирхэг гүрэн гэдгийг таниулан сурталчлах хүчтэй бодлого явуулахыг эрмэлзэж байна.

Жон Хопкинсийн сургуулийн Хятад судлалын салбарын захирал, профессор Дэвид М.Лэмптон саяхан бичсэн “Хятадын хүч чадлын гурван төрх: хүч, мөнгө, оюун санаа” хэмээх номондоо,⁷ хүч чадлыг тулган хүлээлгэх, шагнан урамшуулах, татан дагуулах гэсэн гурван хэлбэрээр илэрхийлж болох бөгөөд товчхоноор буу зэвсэг, мөнгө хөрөнгө, үзэл санаа юм. Хятадын эрх баригчид энэ 3 чиглэлийг ижил түвшинд хөгжүүлэх, цэрэг, эдийн засаг, оюун санааны хүч чадлаа нэгэн зэрэг зузаатгах бодлого явуулж байна. Мао Зэдунгийн үед хүчинд дулдуйдах бодлого, Дэн засгийн эрхэнд гарахдаа эдийн засгийн чадавхиа өсгөх шинэтгэлийн бодлого явуулж байсан бол өнөөгийн ерөнхийлөгч Ху Жинтао материаллаг болон оюуны хүчийг хослуулсан цогц чадавхиа өсгөхийг чармайж байна. Үүнд зохицолтой, тэгш нийгэм, шинжлэх ухаанд тулгуурласан хөгжлийн онолуудыг хамааруулж болох юм.

Лэмптоны дэвшүүлж буй бас нэг чухал санаа бол АНУ Хятадын хүчин зүйлийг хэтрүүлэх эсвэл дутуу үнэлэх нь адилхан маш ноцтой уршиг дагавартай. Хятад маш том, маш чухал, маш эрчимтэй, маш олон орон хамтран ажиллахыг сонирхож буй тул хүчээр шахах эсвэл үл тоох бус, зөвхөн харилцах, зохицох /engagement/-оос өөр сонголт байхгүй гэдгийг цохон тэмдэглэсэн явдал юм.

Ийм байдал Хятадын хөрш зэргэлдээ бүх орнууд, түүний дотор Монгол шиг жижиг оронд хувьд бүр ч илүүтэй илэрч байна.

Хятадын софт хүч чадлын хөгжлийн чиг хандлага

Хятадын эрх баригчдын хөрш орнууд, бүс нутгийн хэмжээнд явуулж буй бодлого, мөн түүнчлэн Монгол-Хятадын харилцаанд гарч буй зарим тулгамдсан, зөрчилтэй асуудлын мөн чанар, учир шалтгааныг ухан ойлгох үүднээс Бээжингийн зүгээс эрх ашиг, нөлөөний хүрээгээ бэхжүүлэх талаар хоёр талын болон хүрээлэн буй бүс нутгийн хүрээнд явуулж буй зөөлөн хүч чадалтай холбогдсон бодлого, үйл ажиллагааны зарим чиглэлээс дурдахад,⁸

1. Хятад улсын нэр хүнд, нөлөө, ялангуяа хөрш болон хөгжиж буй орнуудад софт хүчин чадлын нөлөөгөөр өсч байна. 1990 оны сүүлч үеэс

эхлэн Хятадын хэл, соёл, дипломат бодлого, бизнес, хил худалдаа, урлаг, эмнэлэг, хоол хүнс, спорт гэх мэт олон чиглэлээр гадаадынхны анхаарал сонирхлыг татаж байна.

2. Цэргийн хүч чадлын сөрөг нөлөө бөгөөд хязгаарлагдмал байдлыг харгалзан, хөрш орнуудын маргаантай аливаа асуудлыг /Тайваниас бусад/ цэрэг зэвсгийн хүчээр далайлган шийдвэрлэх хандлагаас аль болох зайлсхийх, хөгжиж буй болон буурай орнуудын эрх ашгийг хамгаалагчийн дүр төрхийг олж авахыг эрмэлзэх болов.

3. Хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалаад зогсохгүй үлгэр дууриал болох, тэдгээр орны эрх баригчид, ард олныг хөгжил цэцэглэл, хүч чадлаараа татан дагуулахыг эрмэлзэж байна. Вьетнам, Лаос, Камбож Хятадын туршлагыг нэн идэвхийлэн ашиглаж байгаа, магадгүй Хойд Солонгос, Мьянмар ч хятад загварыг сонирхон судалж байж болох юм. ОХУ, Латин Америкийн орнууд ч Хятадын зарим туршлагыг хэрэглэж эхэлсэн тухай мэдээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдах боллоо.

4. Хятад улс улс төр, эдийн засаг, хөгжлийн загвараа дэлхий нийтэд идэвхитэй сурталчлах ажиллагаа явуулж байна. Дэлхийн хүн амын 22% хувийг нийт тариалангийн талбайн 10 хүрэхгүй хувийг ашиглан тэжээж, дэлхийн эдийн засгийн хөдөлгөгч хүч болж байгааг яруу тод харуулах явдал хятадын софт хүч чадлын нэгэн чухал чиглэл болж байна. Ардын дипломатын болон хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн хүрээнд ашиглаж байна.

5. Дипломатуудынхаа ур чадварыг дээшлүүлж, залуужуулж, мэргэшүүлэхэд ихэд анхаарч байна. Сүүлийн 15 жилд ГХЯ ахмад дипломатуудыг англи болон тухайн орны хэлийг сайтар эзэмшсэн залуу дипломатуудаар солих ажлыг эрчимтэй явууллаа. 2005 оны байдлаар тус орны 4 000 дипломатын тэн хагасыг 35 хүртэлх насны хүмүүс эзлэх болсны зэрэгцээ дээд албан тушаалын дипломатуудыг бэлтгэх, дадлагажуулах системтэй бодлого явуулж байна. Элчин сайдаар томилохын өмнө тухайн оронд танигдах, нөхцөл байдлыг сайтар судлуулахын тулд янз бүрийн практик ажлуудыг хийлгэж байна. Манай улсад суугаа Хятадын ЭСЯ-ы Улс төрийн зөвлөхөөр ажиллаж байсан Ван Фукань дипломат Монгол дахь томилолт дууссаны дараа хил залгаа Өвөр Монголын нэгэн аймгийн даргаар томилогдсон нь үүний нэгэн жишээ байж болох юм.

6. Хятадын хөгжил түргэсэн дэлхий дахины бизнесийн үйл ажиллагаа тус орон руу чиглэх болсонтой уялдан хятад хэл, соёлын нөлөө ч өсөн нэмэгдэж байна. Хятадын засгийн газар үүнийг бүхий л талаар дэмжих бодлого явуулж байна. “Хятад хэлний гүүр” олон улсын хятад хэлний олимпиад жил бүр зохион байгуулж, гадаад орнуудад Күнзийн сургуулиуд өөрийн хөрөнгөөр байгуулан өгөх, Хятадын их дээд сургуулиудад улсын тэтгэлгээр олон мянган гадаад оюутан, докторант, дадлагажуулагчдыг сургах явдлыг жил бүр өргөжүүлж байна.

7. Эдийн засгийн ялангуяа буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт зэргийг софт хүчин чадлын эдийн засгийн хүчтэй, нарийн арга хэрэгсэл болгож байна. Хятадын зээл, тусламж Африкийн ядуу буурай орнууд төдийгүй Зүүн Өмнөд Азийн /ЗӨА/ орнуудад ч нэмэгдэж байна. ЗӨА орнуудад үзүүлсэн Хятадын тусламж АНУ-ынхаас даруй 2-3 дахин илүү байв. Жишээ нь Филиппинд 4 дахин, Лаост 3 дахин, Индонезид 2 дахин их. Зээл тусламж олгохдоо хөгжингүй орнууд шиг янз бүрийн болзол нөхцөл тавихгүй ердөө “Нэг Хятад”-ын бодлогыг хүлээн зөвшөөрсөн байх л шаардлага тавьдаг ажээ. Чөлөөт худалдааны хэлэлцээр, худалдааны тааламжтай нөхцөл олгох бодлогыг ч ялгавартай явуулж байна.

8. Хятадын эдийн засаг, соёлын нөлөөг дамжуулах, софт хүч чадлын бас нэг том суваг бол хятад иргэдийн шилжилт хөдөлгөөн, цагаачлал юм. Сүүлийн 10 жилд Хятадын засгийн газар улс дотроо төдийгүй хилийн чанад руу хятад иргэдийн шилжин суурьших үйл явцад саад учруулах, хяналт тавих явдлаа нэлээд сулруулсан юм. Хятадууд аялал, жуулчлал, боловсрол, бизнесийн шугамаар гадаад орнууд руу аялахад бараг хориг саадгүй болсон. Энэхүү бодлогын үр нөлөө хил залгаа бүх орнуудад илэрсэн бөгөөд ялангуяа хүн ам цөөн, нягтшил багатай Монгол, ОХУ-ын Сибирь Алс Дорнодын бүсд маш ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байна.

Урьд өмнө ажил амьдрал хайж цагаачилж байсан хятадуудын араас мөнгөө өсгөх гэсэн дунд ангид орж ирсэн жижиг бизнесменүүдийн том урсгал хөрш орнуудыг нөмөрч байна. Тэдэнд албан ёсны эрх, төр засгийн дэмжлэгээс гадна, ашиг орлогын хойноос хөөцөлдөх, хөрөнгө мөнгөө арвижуулахын тулд бүхий л арга сиймхийг ашиглах гэсэн мугуйд хүсэл эрмэлзэл тэднийг гадагш түлхэх гол хүч болж байна. Эдгээр жижиг бизнесменүүдийг даган тухайн орны байгаль, нийгмийн сэтгэл зүйд сөрөг нөлөө бүхий хятадын хоцрогдсон хөдөлмөрийн стандарт нөхцөл, шударга бус менежмент орж ирдэг байна. Сүүлийн жилүүдэд Монгол дахь хятад иргэдтэй холбоотой гэмт хэрэг, авилгал, байгаль орчны ноцтой бохирдол зэрэг хоёр орны харилцаанд ихээхэн төвөг бэрхшээл учруулж буй асуудлын томоохон учир шалтгаан энд оршиж байна. Цаашид ужигран, ноцтой түвшинд хүрч болзошгүй эл асуудлыг хоёр талын хамтын хүчин чармайлтаар, хуулийг, стандарт шаардлагыг хатуу чанд даган мөрдөх, хариуцлага тооцох замаар, макро түвшний бодлого стратегия сайжруулах замаар л шийдвэрлэх боломжтой болохоос цаг үеийн амиа аргацаасан, нийгмийн сэтгэлзүйгээр тоглосон популист арга хэрэгсэл олигтой үр дүнд хүрэхгүй.

9. Хятадын софт хүчин чадлын өсөхийн хэрээр хятад үндэстэн, Хятад орныг ойлгох, мэдэхийг хүссэн хүмүүс бишрэгчдийн тоо ч өсөн нэмэгдэж, бүхэлдээ эерэг хандлага нэмэгдэж байна. Тухайлбал, Австралийн Лоуви Институте-ээс явуулсан санал асуулгаас харахад австраличууд олон жилийн турш холбоотноо хэмээн үздэг АНУ, шинээр

гарч ирж буй хүчирхэг түнш Хятад хоёрыг нэгэн түвшинд тавьж байгаа нь харагдсан байна.

Хэдийгээр ЗӨА-ийн орнуудад нутгийн иргэд хятад цагаачдын хооронд тааламжгүй харилцаа хэвээр буй боловч Хятадын өндөр дээд хэмжээний зочдыг хүлээн авах үед найрсаг зочломтой байдал дээд түвшинд ч, ард олны дунд ч ажиглагдаж байхад Бушийг Индонезид айлчлах үеэр төдийлөн халуун дотно угтаагүй гэсэн мэдээлэл байна.

Хятадын софт хүчин чадлын өсөлт нь зарим талаар олон улсын харилцаанд эерэг нөлөө, нааштай үүрэг гүйцэтгэх боломжтойг сүүлийн үеийн зарим жишээ баримтууд нотолж байна. 2003 онд Тайланд, Камбожийн харилцаа эрс хурцдан дайны ирмэгт тулсан боловч Хятадын идэвхитэй оролцооны үр дүнд асуудлыг тайван замаар шийдвэрлэж чадсан ажээ. Мөн Хойд Солонгосын цөмийн хямралыг тойрсон асуудлыг нааштайгаар шийдвэрлэхэд Хятадын талын гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдлыг 6 талт хэлэлцээнд оролцогч бүх талууд өндөр үнэлдэг.

Өрнөд ба Хятадын софт хүч чадлын “тулаан”

Хятадын софт хүч чадал өсөхийн хэрээр өрнөд ба хятадын хооронд суртал нэвтрүүлгийн маргаан, тэмцэл ширүүсч байна. Хоёр тал бие биенийхээ сул, сөрөг талуудыг ашиглан хүчтэй дайралт, довтолгоо явуулж байна. Улиран буй 2007 он Хятадын хувьд өрнөдийн зүгээс ирсэн үзэл суртал, улс төрийн янз бүрийн дарамтыг даван туулах, сөрөх хүндхэн зорилттой тулгарсан юм. Юуны өмнө Хятадын эдийн засаг, санхүүгийн хүч чадал, шинжлэх ухаан, технологийн потенциал өсөн нэмэгдэж, уйгагүй явуулж буй геополитикийн болон геозэдийн засгийн бодлогоо зээл тусламжаар эээр татах дипломат бодлогын үр дүнд хөрш орнууд болон хөгжиж буй орнуудын дунд Хятадын нэр хүнд дээшилсэн буюу харилцааны түвшин сайжирсан явдал өрнөдийнхний сэтгэлийг түгшээж байна. Хятадын бизнес, бараа таваар өрнөдийн нөлөөг бууруулж уламжлалт нөлөөний хүрээн дэх байр суурийг шахаж эхэлсэн нь софт хүч чадлаараа “дайтахад” хүргэж байна. Оросын нөлөө бүхий “Известия” сонинд бичсэнээр хөгшин Европын хувьд “Хятад луу”-г гол төлөв эдийн засгийн аюул занал хэмээн үзэж буй бол америкуудын хувьд эдийн засгаас гадна геополитикийн аюул гэж үзэж байна. Хятадууд Ази-Номхон далай, Африк, ялангуяа Вашингтоны хамгийн эмзэг газар болох Латин Америкт америкуудыг шахаж эхэлсэн тул ингэж үзэхээс өөр аргагүй юм.⁹

Өрнөдийнхөн хятад луугийн түрэлтийг зогсоохын тулд Бээжинд дарамт шахалт үзүүлэх нөхцөл байдал, цаг хугацаа, эмзэг газруудыг тун гярхай тооцоолсон нь тэнд Хятадыг бүх талаас нь нарийн нямбай судалж, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид судлаач шинжээчдийнхээ хүч бололцоог бүрэн дүүрэн ашиглаж буйтай холбоотой. 2007 оны турш дэлхийн

хэвлэл, мэдээллийн хэрэгслийн гол бай нь хятад барааны чанар /хүүхдийн тоглоом, эм, хүнсний бараа/, юаний ханш, байгаль орчны бохирдол, хүний эрхийн зөрчил болон харгис дэглэмүүдийг дэмжсэн хятадын байр суурийн асуудал байсан нь санамсаргүй тохиолдол биш юм.

Юуны өмнө АНУ, өрнөдийн орнуудын Хятадтай хийж буй худалдааны алдагдал эрс өсч байна. 2006 онд АНУ 765.3 тэрбум долларын алдагдал хүлээсний 232.5 тэрбум нь Хятадын “хувь нэмэр” ажээ. Нөгөө талаас БНХАУ-ын эрх баригчдын хувьд амин чухал ач холбогдол бүхий хоёр томоохон үйл явдал бол яах аргагүй засгийн эрхийг дангаар барьж буй ХКН-ын ХҮП их хурал, дэлхий нийтийн анхаарал төвлөрч буй 2008 оны Бээжингийн Олимпийн наадам хоёр юм. Хятадын эрх баригчид энэ хоёр арга хэмжээг амжилттай зохион явуулж, Хятад улсын хөгжил цэцэглэл, сүр хүч, нэр хүндийг өсгөх, өөрийн бодлого, үйл ажиллагааны ололт амжилт, давуу талыг сурталчлан таниулах, дэлхийн сая сая хүмүүсийн сэтгэхүйг байлдан дагуулахыг зорьж буй нь нууц биш асуудал юм. Өөрөөр хэлбэл, Бээжин софт хүч чадлаа зузаатгах, өрнөдийн зүгээс явуулж буй суртал ухуулгын дайнд улс төр-дипломатын ялалт байгуулах нь тулгамдсан асуудал болж байна.

Хятадын улс төрчид, судлаачдын хувьд хамгийн хүнд асуудал бол АНУ-ын зүгээс үзүүлж буй улс төр, эдийн засгийн дарамт шахалт юм. Гэхдээ энд онцолж тэмдэглэх ёстой зүйл бол АНУ, Хятадын эдийн засаг, санхүү, зах зээл урьд байгаагүй хэмжээгээр уялдан холбогдсон, өөрөөр хэлбэл аливаа буруу алхам хэн хэнийгээ чирэх түвшинд хүртлээ интеграцлагдсан явдал юм. Тухайлбал, Хятад улс эдүгээ 1.4 триллионы заагийг даваад буй гадаад валютын нөөцийнхөө 70 орчим хувийг ам.доллараар бүрдүүлж буйн зэрэгцээ АНУ-ын холбооны нөөцийн /Төв Банкны/ арилжих эрхтэй нийт бондын 15% буюу засгийн газрын өрийн 15%-ийг хятадууд хянаж байгаа гэсэн үг юм.

Софт хүч чадал багагүй хүч хөрөнгө шаарддаг тул нөлөөний хүрээгээ өргөжүүлэхийн төлөө өрсөлдөж буй их гүрнүүд тухайлбал АНУ, Энэтхэг, ОХУ, Хятад зэрэг орнууд бие биедээ сэтгэл зүй, санхүүгийн асар дарамт, өрсөлдөөнийг бий болгож байна. Энэ өрсөлдөөн магадгүй Хятадыг ч туйлдуулах аюул буйг шинжээчид онцлон тэмдэглэж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Beijing increases defense spending, By David Lague Sunday, International Herald Tribune, March 4, 2007
2. Joseph Nye, The transformation of World Power, *Dialogue* , No. 4, 1990; Soft Power, *Foreign Policy*, Fall 1990;
3. Joseph Nye and William Owens, America’s Information Edge, *Foreign Affairs*, March-April, 1996; Keohane and Nye, Power and Interdependence in the Information Age , *Foreign Affairs*, September-October 1998;
4. Joseph Nye, Hard Power and Soft Power, *The Boston Globe*, August 6, 1999
5. Ван Хунин, “Улсын хүч чадал болж буй соёл: софт хүч чадал”, Фудан Их сургуулийн эрдэм шинжилгээний цуврал, 1993 он, №3 (王沪宁, “作为国家实力的文化: 软实力” 复旦学报, 1993年第3期)
6. China’s forex reserve tops \$1.43 trillion, October 12, 2007, <http://news.xinhuanet.com>
7. David M. Lampton The Faces of Chinese Power, , *Foreign Affairs*, January/February 2007, pp -115-127
8. Chinese Soft Power in Southeast Asia (Part I,II)By Josh Kurlantzick | Monday, July 02, 2007я “*The Globalist*” Charm Offensive: How China’s Soft Power Is Transforming the World by Josh Kurlantzick. Copyright 2007, Yale University Press.
9. Игорь Явлинский, Кто усмирят китайского дракона, *Известия*, 25 Сентября, 2007